



МОНГОЛБАНКНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

/Товч танилцуулга/

Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч, Төв банкны хувьд Монголбанкны хүний нөөцийн хөгжилд баримтлах үндсэн чиглэл нь Монголбанкны аппаратыг цомхон, мэдлэг чадвартай ажилтнуудаар бүрдүүлж, банкны олон талт мэдлэг бүхий тогтвор суурьшилтай хүний нөөцтэй байх, хүний нөөцөө тасралтгүй хөгжүүлж байхад чиглэгдэнэ.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан үйл ажиллагааны чиглэл, зорилтыг биелүүлэхтэй холбогдуулан банкны үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх хянан шалгагч, гадаад валютын улсын нөөцийг удирдах, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, мөнгөний бодлого боловсруулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажилтнуудыг бид Монголын болон олон улсын их дээд сургуулийг банк, санхүү, нягтлан бодох бүртгэлээр амжилттай төгсөж, Монголбанкны сонгон шалгаруулалтын шалгалтад тэнцсэн байх шаардлага тавьдаг бөгөөд англи хэлийг мэргэжлийн ажил гүйцэтгэх түвшинд эзэмшсэн, ёс зүйн хувьд төлөвшсөн, судалгаа хийж дүгнэлт гаргах, бодлогын баримт бичиг боловсруулах чадвартай байх гэсэн шалгуураар сонгон шалгаруулж авдаг юм.

Манай байгууллага ажилтан шалгаруулж авахдаа шударга, ил тод байдлыг эрхэмлэдэг. Мөн ажиллагсадаа бусад төрийн байгууллагуудтай өрсөлдөхүйц хэмжээний цалин олгох мөн ажилтнуудынхаа нийгмийн бусад асуудалд байнга анхаарал хандуулах бодлого баримталж байна. Хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн зах зээлийн ханш, ижил төстэй үйл ажиллагаа бүхий төрийн байгууллагуудын цалин хөлсний системийг судалж тогтоодог.

Байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, сайжруулахын тулд суралцах, шинэ арга барил эзэмшихийг идэвхтэй дэмжинэ. Ажиллах орчны нөхцөл нь мэдлэг чадварыг бий болгох явдлыг дэмжиж, ажилтны өдөр тутмын ажил нь суралцаж хөгжих таатай орчин байна.

Хүний нөөцийн сургалт хөгжлийн тэргүүлэх чиглэлийг үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан тогтоож, эдгээр чиглэлийг эхний ээлжинд түлхүү хөгжүүлнэ. Сургалтын үйл ажиллагааны хүрээнд ажиллагсдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах чадавхи бий болгох сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлнэ.

Монголбанкинд гарсан ажлын байрны зарыг тухай бүрт нь өдөр тутмын сонинуудад мөн www.mongolbank.mn цахим хуудсанд байршуулна.

ТАМГЫН ГАЗАР
2011 он